

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/153/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn (Хотын нэр оруулах) 2018 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
	Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
	Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
	Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
	Аудитор: Б.Уранбилэг
	Утас: 99064332 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	(Аудитын чиглэл).....	
3.1.1	Илрүүлэлт:.....	
3.1.2	Эрсдэл:	12
3.1.3	Өгсөн зөвлөмж:	12
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
3.2	(Аудитын чиглэл).....	
3.2.1	Илрүүлэлт:.....	
3.2.2	Эрсдэл:	
3.2.3	Өгсөн зөвлөмж:	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,

Орон нутгийн өмчийн Ш байр.

Утас: (705) 2-27-34

2019.02.13

№

1-6/56

танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭСГИЙН
ДАРГА Л.БАТЧУЛУУН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Замын-Үүд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Замын-Үүд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Л.Баатарчулуунд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 11-нээс 2019 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын эрхэм зорилго нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлсноор Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх;
- Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах;

- Иргэний, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах мэргэшүүлж, алба хаах нөхцөл, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангах;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг олон улсын жишигт хүргэх;
- Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа хэвийн явагдах техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл болон материаллаг бааз суурийг бэхжүүлэх;
- Үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийг түшиглэсэн үйлдвэр, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар дотоод эх үүсвэрийг бий болгох.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Сэжигтэн ялагчдыг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль
- Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр барагдуулах тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл Дунд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Unicus2 програм хангамж ашигладаг байна.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн шатанд тодорхойлсон нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлаар материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нийт хөрөнгийн дүн их, нарийвчлан үзэх шаардлагатай гэж үзсэнтэй холбоотой юм.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны нийт зардал эхний хагас жилийн байдлаар 90,306.4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 903.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь санхүүгийн тайланг нарийвчлан үзэхтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав. Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	593500	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
2	Төлбөрийн акт тогтоосон	1	72847	Цалин илүү тооцож олгосон
3	Албан шаардлага өгсөн	1	61886	Дутуу тооцож олгосон ээлжийн амралтын олговор
	Дүн	3	728233	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой

Тус байгууллагын шийдвэр гүйцэтгэгч Т.Отгонтуяад 2018 оны ээлжийн амралтын олговрыг тооцохдоо 100.4 мянган төгрөг дутуу, 2018 оны 10 дугаар цалинг 38.5 мянган төгрөгийг илүү тус тус тооцож олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”, Засгийн газрын 2018 оны

“Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шийдвэр гүйцэтгэгч Т.Отгонтуяагийн ээлжийн амралтын олговрын дүнгээс илүү олгосон цалинг хасаж нийт 61.9 мянган төгрөгийг нөхөн олгох тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Тус байгууллагын нягтлан бодогч Н.Далайжаргалд 2018 оны 09 дүгээр сард /ээлжийн амралтын хугацаанд/ 72.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч Н.Далайжаргалд илүү тооцож олгосон дээрх 72.8 мянган төгрөгийг буцаан төлүүлэх тухай төлбөрийн актыг тогтоохоор шийдвэрлэв.

2.8.1.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

2018 онд тус байгууллага нь зардлын бүлэг хооронд шилжүүлэх зөвшөөрөлгүйгээр “Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйл” зардлаас 593.5 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5 дахь хэсэгт заасан “Зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх хязгаар”-ыг баримталж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 4 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 143561.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 143332.1 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь батлагдсан орон тооноос 1 орон дутуу ажилласнаас шалтгаалжээ. Үүнээс 229.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.10 Шилэн дансны мэдээлэл

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ

2018 онд тус байгууллага нь зардлын бүлэг хооронд шилжүүлэх зөвшөөрөлгүйгээр “Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйл /хангамж, бараа материалын зардал/” зардлаас 593.5 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5 дахь хэсэгт заасан “Зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх хязгаар”-ыг баримталж ажиллаагүй байна.

3.1.1 Эрсдэл:

Батлагдсан төсвийг холбогдох зөвшөөрөлгүйгээр зориулалт бусаар зарцуулах.

3.1.2 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Нягтлан бодогчоос тайлбаргүй гэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,240,652.31	13,096,013.69
33	АВЛАГА	348,333.31	428,628.69
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	185,500.00	428,628.69
33500	Бусад авлага	162,833.31	0.00
3351	Байгууллагаас авах авлага	162,833.31	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,892,319.00	12,667,385.00
35100	Түүхий эд материал	1,878,406.00	0.00
35110	Тусгай зориулалттай материал	1,652,856.00	0.00
35130	Эм,боох материал	225,550.00	0.00
35400	Хангамжийн материал	16,013,913.00	12,667,385.00
35410	Бичиг хэргийн материал	4,344,303.00	3,924,740.00
35420	Аж ахуйн материал	5,654,976.00	4,706,796.00
35440	Түлш,шатах тослох материал	2,134,445.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	3,880,189.00	4,035,849.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	193,496,961.79	196,872,830.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	193,496,961.79	196,872,830.20
392	Биет хөрөнгө	189,232,269.68	188,547,676.61
39201	Барилга,байгууламж,орон сууц	185,411,500.00	161,839,780.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	19,276,406.03	0.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,634,574.47	50,634,574.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	47,849,704.48	50,634,574.47
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	26,279,540.95	36,118,498.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	7,608,677.60	12,417,385.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,700,222.00	5,567,542.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	2,058,779.63	2,560,758.91
39300	Биет бус хөрөнгө	4,264,692.11	8,325,153.59
39301	Програм хангамж	7,297,692.31	7,297,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	3,033,000.20	4,492,538.72
39303	Бусад биет бус хөрөнгө	0.00	5,520,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	211,737,614.10	209,968,843.89
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	326,852.97
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	326,852.97
41300	Өглөг	0.00	326,852.97
41360	Бусад өглөг	0.00	326,852.97
41361	Байгууллагад өгөх өглөг	0.00	326,852.97
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	211,737,614.10	209,641,990.92
51	Засгийн газрын хувь оролцоо	211,737,614.10	209,641,990.92
51101	Засгийн газрын оруулсан капитал	0.00	5,520,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	211,737,614.10	223,876,203.39
51210	Өмнөх үеийн үр дүн	211,737,614.10	211,737,614.10
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	12,138,589.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	0.00	-19,754,212.47
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	211,737,614.10	209,968,843.89

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	111,878,200.00	149,476,137.60
12	<u>ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,026,000.00	133,780.00
120	<u>Нийтлэг татварын бус орлого	20,026,000.00	133,780.00
120004	<u>Төсөв байгууллагын өөрийн орлого	20,026,000.00	133,780.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	133,780.00
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	91,852,200.00	149,342,357.60
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс	77,313,500.00	143,561,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	77,313,500.00	143,561,400.00
1330	<u>Төсвийн захирагчдаас	14,538,700.00	5,780,957.60
133003	Хөрөнгийн	14,538,700.00	5,780,957.60
II	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	107,115,065.40	134,030,342.31
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ	107,115,065.40	134,030,342.31
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,815,065.41	133,800,435.31
21.0	<u>ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	56,889,982.06	77,747,169.79
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	53,547,608.93	73,934,023.82
210101	Үндсэн цалин	43,986,766.50	64,476,171.31
210102	Нэмэгдэл	9,383,842.43	8,957,852.51
210104	Урамшуулал	0.00	500,000.00
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,342,373.13	3,813,145.97
210201	Тэтгэврийн даатгал	0.00	642,651.49
210205	Эрүүл мэндийн даатгал	3,342,373.13	3,170,494.48
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,058,886.20	11,556,330.80
210301	Гэрэл, цахилгаан	543,054.00	1,079,929.00
210302	Түлш, халаалт	7,550,570.20	9,715,401.80
210303	Цэвэр, бохир ус	2,965,262.00	761,000.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	10,196,684.57	14,746,838.00
210401	Бичиг хэрэг	2,656,878.00	3,473,448.00
210402	Тээвэр, шатахуун	2,983,162.57	5,691,445.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,453,369.00	2,468,352.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	91,450.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,011,825.00	3,113,593.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	7,178,250.00	13,308,350.00
210604	Урсгал засвар	7,178,250.00	13,308,350.00
2107	<u>Томилолт, зочны зардал	2,164,500.00	1,985,500.00
210702	Дотоод албан томилолт	2,164,500.00	1,985,500.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	734,650.00	1,360,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	23,150.00	140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	81,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	107,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500.00	764,500.00
210807	Газрын төлбөр	5,000.00	216,850.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	16,592,112.58	13,096,196.72
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	16,392,112.58	13,096,196.72
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,299,999.99	229,907.00
2133	<u>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	200,000.00	229,907.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	200,000.00	229,907.00
III	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	4,763,134.60	15,445,795.29
IV	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	0.00	0.00
145006	Гадаадын санхүүгийн а зээлээс санхүүжих	0.00	0.00
V	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,968,072.93	3,307,206.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,968,072.93	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	3,307,206.00
VI	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,795,061.67	12,138,589.29

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө	0.00	0.00
1	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	97,339,500.00	143,561,400.00
12	<u>ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,026,000.00	0.00
120	<u>Нийтлэг татварын бус орлого	20,026,000.00	0.00
120004	<u>Төсөв байгууллагын өөрийн орлого	20,026,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,026,000.00	0.00
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	77,313,500.00	143,561,400.00
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс	77,313,500.00	143,561,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	77,313,500.00	143,561,400.00
2	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,339,500.00	120,601,400.00
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ	97,339,500.00	120,601,400.00
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,039,500.01	120,371,493.00
21.0	<u>ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	56,121,142.01	77,848,293.00
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	52,531,142.01	74,362,000.00
210101	Үндсэн цалин	42,554,000.00	64,904,800.00
210102	Нэмэгдэл	9,777,142.01	8,957,200.00
210104	Урамшуулал	200,000.00	500,000.00
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,590,000.00	3,486,293.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	642,651.49
210205	Эрүүл мэндийн даатгал	3,590,000.00	2,843,641.51
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,046,000.00	11,511,000.00
210301	Гэрэл, цахилгаан	543,054.00	1,079,929.00
210302	Түлш, халаалт	8,691,946.00	9,670,071.00
210303	Цэвэр, бохир ус	811,000.00	761,000.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	17,995,858.00	12,607,000.00
210401	Бичиг хэрэг	5,271,751.00	2,252,715.00
210402	Тээвэр, шатахуун	4,031,445.00	4,557,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,623,589.00	3,027,022.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,069,073.00	2,770,263.00
210407	Түлш шатахуун,тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд	0.00	0.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	7,475,000.00	14,362,000.00
210604	Урсгал засвар	7,475,000.00	14,362,000.00
2107	<u>Томилолт, зочны зардал	2,350,000.00	1,800,000.00
210702	Дотоод албан томилолт	2,350,000.00	1,800,000.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	851,500.00	1,243,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,000.00	140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	81,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,000.00	107,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	554,500.00	764,500.00
210807	Газрын төлбөр	5,000.00	100,000.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	300,000.00
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,299,999.99	229,907.00
2132	<u>Бусад урсгал шилжүүлэг	2,099,999.99	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,099,999.99	0.00
2133	<u>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	200,000.00	229,907.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	200,000.00	229,907.00

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	22,960,000.00
5	<u>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	22,960,000.00
22	<u>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	22,960,000.00
2200	<u>Дотоод эх үүсвэрээр	0.00	22,960,000.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	22,960,000.00
6	<u>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-22,960,000.00
8	<u>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
9	<u>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.00	0.00
10	<u>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.00	0.00

4.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
2017 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	0.00	211,737,614.10	211,737,614.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,520,000.00	0.00	0.00	5,520,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-19,754,212.47	0.00	-19,754,212.47
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	12,138,589.29	12,138,589.29
2018 оын 12 сарын 31-р үлдэгдэл	5,520,000.00	-19,754,212.47	223,876,203.39	209,641,990.92

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	143,561,400.00	143,331,493.00	229,907.00	99.84
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	143,561,400.00	143,331,493.00	229,907.00	99.84
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	143,561,400.00	143,331,493.00	229,907.00	99.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,483,200.00	65,483,200.00	0.00	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	74,362,000.00	74,362,000.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	63,984,800.00	64,904,800.00	920,000.00	101.44
210102	Нэмэгдэл цалин	9,877,200.00	8,957,200.00	920,000.00	90.69
210104	Урамшуулал	500,000.00	500,000.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,716,200.00	3,486,293.00	229,907.00	93.81
210201	Тэтгэврийн даатгал	0.00	642,651.49	642,651.49	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,716,200.00	2,843,641.51	872,558.49	76.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,511,000.00	11,511,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,050,000.00	1,079,929.00	-29,929.00	102.85
210302	Түлш, халаалт	9,700,000.00	9,670,071.00	29,929.00	99.69
210303	Цэвэр, бохир ус	761,000.00	761,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,607,000.00	12,607,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	2,800,000.00	2,252,715.00	547,285.00	80.45
210402	Тээвэр, шатахуун	4,207,000.00	4,557,000.00	350,000.00	108.32
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,600,000.00	3,027,022.00	427,022.00	116.42
210406	БҮТЭЭҮЙЛС	3,000,000.00	2,770,263.00	229,737.00	92.34
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,322,000.00	37,322,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник хэрэгсэл	3,960,000.00	3,960,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	33,362,000.00	33,362,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,800,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,243,200.00	1,243,200.00	0.00	100.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	140,000.00	140,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,700.00	81,700.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,000.00	107,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	764,500.00	764,500.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00	0.00	100.00

Замын-Үүд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	300,000.00	0.00	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	143,561,400.00	143,331,493.00	229,907.00	99.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,561,400.00	143,331,493.00	229,907.00	99.84
131001	Улсын төсвөөс санхүүжих	143,561,400.00	143,331,493.00	229,907.00	99.84